

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨМЖ (2016 он)

1. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201603/01. ИНЕГ-т. /Safety recommendation 201603/01. МСАА/.

PWC SB 20768 бюллетений дагуу зохих сайжруулалтыг холбогдох хөдөлгүүрүүдэд хийлгэх арга хэмжээг авах

2. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201603/02. ИНЕГ-т. /Safety recommendation 201603/02. МСАА/.

Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын хадгалалттай холбогдолтой үйлдвэрлэгчийн бюллетенийг үнэлж судлах, дүгнэлтийг баримтжуулах ажиллагаанд хяналт тавих.

3. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201603/03. ИНЕГ-т. /Safety recommendation 201603/03. МСАА/.

Агаарын хөлгийн үндсэн болон туслах хөдөлгүүр, сэнс үйлдвэрлэгчийн хуваарьт техник үйлчилгээний шаардлага, түүний өөрчлөлтийг агаарын тээвэрлэгч судлан агаарын хөлгийн техник үйлчилгээний хөтөлбөртөө тусгасан эсэхэд хяналт тавих.

4. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201603/04. ИНЕГ-т. /Safety recommendation 201603/04. МСАА/.

Үйлдвэрлэгчийн техник үйлчилгээний хөтөлбөрт тусгасан техник үйлчилгээний үечлэлийг уртасгасан эсхүл үечлэлийг хэмжих нэгжийг өөрчилсөн агуулга бүхий техник үйлчилгээний хөтөлбөр, түүний өөрчлөлтийг хянаж батлахдаа нислэгт тэнцэх чадварын хадгалалтанд сөргөөр нөлөөлөөгүйг бататгах дүн шинжилгээ, судалгаа, эрсдэлийн үнэлгээг үндэслэх.

5. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201603/05. ИНЕГ-т. /Safety recommendation 201603/05. МСАА/.

On condition maintenance хөтөлбөрийн дагуу ашиглагдаж буй хөдөлгүүрийн тосны зарцуулалтын хяналт (oil consumption monitoring), тосны спектр анализийн шинжилгээ эсхүл түүнтэй адилтгах техник үйлчилгээг үйлдвэрлэгчийн зөвлөсөн үечлэлээр эсхүл бусад агаарын тээвэрлэгчийн ашиглалтын туршлага дээр үндэслэн хийх шаардлагыг агаарын тээвэрлэгчийн техник үйлчилгээний хөтөлбөрт тусгуулах арга хэмжээг авах.

6. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201603/06. ИНЕГ-т. /Safety recommendation 201603/06. МСАА/.

ICAO, DOC 9760, 9.10.9 –д заасан осолд орсон агаарын хөлгийн эд ангийг ашиглах, худалдахад тавигдах шаардлагыг холбогдох иргэний нисэхийн дүрэм эсхүл зөвлөмжийн цувралд тусгах.

7. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201603/07. ИНЕГ-т. /Safety recommendation 201603/07. МСАА/.

Гадаадын сургалтын байгууллагыг гэрчилгээжүүлэхдээ ICAO, Doc 9841, Chapter 12, 12.2.1-д заасны дагуу дотоодын сургалтын байгууллагыг гэрчилгээжүүлэхэд тавигддаг зарчим, шаардлагын дагуу аудит шалгалтыг бүрэн явуулах эсхүл 12.2.2, 12.3-д заасан зарчмыг хэрэгжүүлэх

8. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201603/08. ИНЕГ-т. /Safety recommendation 201603/08. МСАА/.

ICAO, Annex 1, Appendix 2, 1.1 (c)-д заасны дагуу terms of approval буюу зөвшөөрлийн нөхцлийг сургалтын байгууллагын гэрчилгээн дээр тодорхой заах

9. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201603/09. ИНЕГ-т. /Safety recommendation 201603/09. МСАА/.

ИНД 121 дүрмийн И болон К бүлэгт заагдсан нисгэх багийн сургалт, ур чадварын шалгалтын шаардлагын биелэлтэнд хяналт тавих тогтолцоогоо сайжруулах.

10. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201603/10. ИНЕГ-т. /Safety recommendation 201603/10. МСАА/.

Агаарын тээвэрлэгч агаарын хөлгийн хөдөлгүүр, систем, их бие, гал болон бусад хэвийн бус нөхцөлөөс шалтгаалсан нислэгийн бүх төрлийн онцгой болон хэвийн бус тохиолдлын давтан сургалтыг дадлагажуур дээр хуваарийн дагуу бүрэн хийх тогтолцоог сайжруулах арга хэмжээг авах

11. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201603/11. ИНЕГ-т. /Safety recommendation 201603/11. МСАА/. Агаарын тээврийн компаниудын “Техник үйлчилгээний байгууллагын ерөнхий заавар”-т тусгагдсан, техник үйлчилгээг гүйцэтгэх, гэрчилгээжүүлэх ажилтанд эрх олгох журмыг ИНД 145.60-д заасан шаардлагатай нийцүүлэх арга хэмжээг авах

12. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201603/12. ИНЕГ-т. /Safety recommendation 201603/12. МСАА/. Агаарын тээврийн компаниудын “Техник үйлчилгээний байгууллагын ерөнхий заавар”-т тусгагдсан, техник үйлчилгээг гүйцэтгэх, гэрчилгээжүүлэх ажилтаны эдлэх эрхийг ИНД-66 дүрэм болон АС66-1- тэй нийцүүлэх арга хэмжээг авах

13. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201603/13. ИНЕГ-т. /Safety recommendation 201603/13. МСАА/. Агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтаны үнэмлэхний ангилал, зэрэглэлийг ИНД-66 дүрмийн шаардлагатай нийцүүлэн олгох

14. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201603/14. ИНЕГ-т. /Safety recommendation 201603/14. МСАА/. Агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтаны үнэмлэх олгох шалгалтыг ИКАО, Аппех 1, 4.2.1.2 - ын дагуу өргөдөл гаргасан ангилалтай уялдуулан авах, үнэмлэх олгоход шаардлагатай ангилалын дадлага, туршлагын шаардлагыг өргөдөл гаргагч хангасан эсэхийг нарийвчилан шалгах тогтолцоог бүрдүүлэх

15. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201603/15. ИНЕГ-т. /Safety recommendation 201603/15. МСАА/. Нисгэгчийн үнэмлэх, ангилал олгох мэдлэгийн болон нислэгийн шалгалтыг ИНД-61 дүрэмд заасны дагуу тухайн ангилалын шаардлагатай уялдуулан бүрэн авдаг болох.

16. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201603/16. ИНЕГ-т. /Safety recommendation 201603/16. МСАА/.

Бүх нисэх буудлын оролт, гаралтын болон ойртолтын 80 км доторх бүсэд үйлдэх нислэгийн журам /SID, STAR/-ыг дахин шинээр боловсруулан мөрдөх, тэдгээрийн суурь байр зүйн газрын зургаар ГХГЗЗГ-ын улсын мэдээллийн санд орж баталгаажсан 1:100000-ны масштабын, агаарын замын нислэгийн аюулгүйн доод өндөр (MSA) 1:1000000, 1:500000 масштабын байр зүйн зургийг ашиглах

17. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201603/17. ИНЕГ-т. /Safety recommendation 201603/17. МСАА/. Уулархаг бүсийн Баян-Өлгий, Ховд, Завхан, Баянхонгор, Овоот зэрэг зарим нисэх буудлын буултын оролт үйлдэх, хөөрсний дараа гаралтын бүсэд орших өндөрлөгүүдэд(уулын өндөрт) сонголтоор 2-3 цэгт хяналтын хэмжилт хийж баталгаажуулах

18. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201603/18. ИНЕГ-т. /Safety recommendation 201603/18. МСАА/. Нисэх буудлын аэродромын ойртолт, оролт, гаралтын бүсийн болон агаарын замын дагуу орших бүх саадын өндрийг зөвхөн нэг төвшнөөс тооцож байх журам тогтоож нийт бие бүрэлдэхүүнд судлуулж, мөрдүүлэх

19. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201606/19. ИНЕГ-т. /Safety recommendation 201603/19. Нислэгийн мэдээллийн эмхэтгэл АIP болон агаарын хөлгийн даргын ашигладаг Jeppesen-д тусгагдсан Ховд нисэх буудлын оролт гаралтын схемийн алдааг тус тус залруулж, эдгээр баримт бичгүүдийн хоорондын зөрүүг арилгах, “Улсын геодези зураг зүйн газар”-аас баталгаажсан 1:100000–ны масштабын суурь зургийг ашиглан нислэгийн журмыг дахин зохиож мөрдөх

20. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201606/20 ИНЕГ-т. /Safety recommendation 201603/20. Ховд нисэх буудлын зурвасны газардах цэгт байрлуулсан ил харааны гэрлэн дохиолол РАPI-ийн өнцөг 3 градусаар суурилуулагдсан, нислэгийн мэдээллийн эмхэтгэл болон нисэх багийн ашигладаг зааварт буултын оролт үйлдэх гулгалт (глиссад)-ын өнцөг 3 градус 43 минут буюу 6% налууутайгаар тусгагдсныг нэг утганд оруулж холбогдох баримт бичигт тусгаж хэрэгжүүлэх

21. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201606/21 ИНЕГ-т. /Safety recommendation 201603/21. Ховд нисэх буудлын хөөрөлт буултын зурвасанд 34-ын чиглэлээр буултын оролт үйлдэж байгаа агаарын хөлгийн тэгшлэх (3-5 метрийн өндрийн) үеийн үзүүрт байрлуулсан ил харааны дохиолол конусан салхи заагчийн ойролцоо цаг уурын автомат станц тавьж AWOS-ийн дэлгэцийг нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд ашиглах.

22. Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201606/22 ИНЕГ-т. /Safety recommendation 201603/22. Олон улсын нисэх байгууллагын үйл ажиллагааны практикт нэвтэрсэн орон нутгийн физик газар зүйн онцлог, хөөрч буух зурвасны үзүүлэлтээс хамаарч агаарын хөлөг үйлдвэрлэгчийн тогтоосон хөндлөнгийн салхины зөвшөөрөгдөх хэмжээг нислэгийн аюулгүй байдлын шаардлагад нийцүүлэн тогтоож мөрдөх.

НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБА